

Манмин Мэдээ

№ 65 2018 оны 10 сарын 28

“Библи уншиж ишлэл цээжлэнэ гэдэг ерөөлийн авах нууц юм!”

Эрэгтэйчүүдийн багийн нэгдсэн холбооны зохион байгуулж буй 18 дах удаагийн сургаал үгсийн тэмцээн



2018 он 9-р сарын 16 ний Эзэний өдрийн оройн мөргөлийн дараа эрэгтэйчүүдийн багын ерөнхий холбооноос зохион байгуулж буй 18 дах удаагийн сургаал үгсийн тэмцээний эхний үе шат ба шөвгийн шалгаруулалт интернэтээр шууд дамжуулагдан явагдсан юм. И Жей руг пастор “Учир нь энэ нь Бурханы үгээр ба залбирлаар ариусгагддаг.” гэж айлдсан үгийн дагуу тэрээр ‘Бурханы нэгдүгээрт хайрлаж, Түүний зүрх сэтгэлийг дуурайх нь итгэлийн амьдралын гол цөм ба үг ба залбирлаар зэвсэглэснээр ариун байдалд хүрнэ’ гэж тэр онцолдог юм.

Ялангуяа ‘Хайрын бүлэг’, ‘Найман ерөөл’, ‘Ариун Сүнсний 9н үр жимс’ зэрэг ариусгалд хүргэх үг сургаалтай хамт өдөр бүр библийн нэг бүлгээс дээш уншиж, нэг ишлэл цээжлэх тухай сургамжилсаар ирсэн юм. Тиймээс 2001 оноос эхлэн 7 хоног бүр сүмийн мэдээлэлийн номын арын хуудсанд ‘Энэ долоо хоногийн библийн ишлэл’-г нийтэлж, байгааг Эрэгтэйчүүдийн багийн нэгдсэн холбооноос итгэгч нарын үг сургаалиар зэвсэглэхэд дөхөм болгохын тулд жил бүр сургаал үгсийн тэмцээнийг зохион явуулдаг юм.

Энэ удаагийн тэмцээн нь 2018 оны 8-р сарын 26 нд анхан шатны болон дараагийн шатны шалгаруулалт болж, нийт 96 хүн (Төв сүмээс 70 хүн, Салбар сүмээс 26 хүн) хоорондоо сургаал үгсийн сайны тэмцлээр хүчтэй өрсөлдөн, шөвгийн шалгаруулалтад үлдсэн юм.

Уг тэмцээний гүйцэтгэх даалгавар нь сүмийн мэдээлэлийн номд 1 жилийн турш нийтлэгдсэн ‘Энэ долоо хоногийн библийн ишлэл’ (2017 оны 8-р сараас-2018 он 7-р сар) хүртэл байсан ба мөн үг сургаалийн сүнс талын утгыг ойлгон өөрийн амьдралдаа хэрэгжүүлэхүйц төрөл бүрийн асуултуудын хамт байсан юм.

Энэ жил 16-75 хүртэлх насны хүмүүс оролцсон бөгөөд хамгийн залуу оролцогч нь Паг Жү эл ах дүү (Дэежон Манмин цуглаан) байсан бол хамгийн ахмад оролцогч нь Со Гөн жун ахлагч (Төв сүм) байлаа. Мөн Ким Ги сог пастор, эхнэр И Гё өн халамжлагчийн хамт, Жу Мин геон номлогч ээж Жон Бёон хи халамжлагч болон төрсөн ах Жу Сог ги ах дүүгийн хамтаар оролцож, Паг Хүн ёон пастор (Дэежон Манмин цуглаан) хүү Паг Жү элтэй хамт шөвгийн шалгаруулалтад үлдсэн нь итгэгч нарын анхаарлыг

татаж байлаа.

Мөн түүнчлэн аавтайгаа хамт 3 жилийн турш шөвгийн шалгаруулалтад үлдсэн Паг Жү эл ах дүү нь “6 настайгаасаа библийн ишлэл цээжилж эхлэсэн ба мөргөлийн үед мэддэг ишлэл гарвал сургаалийг илүү анхааралтай сонсч, сүнс талаар их өсч, ой тогтоолт цээжлэх тал дээр их хөгжсөн тул хичээл хийхэд маш их дэм болсон. Энэ хичээлийн жилийн 1-р улиралд бүх сурагчдаас сурлагаараа манлайлж 1-рт орсоноороо Бурхандаа алдрыг өргөх болсондоо маш их баяртай байна” гэсэн юм.

Хүү болон охинтойгоо энэ анх удаа шөвөгт шалгарсан Жон Бёон хи халамжлагч нь “Юугаар Эзэнээ баярлуулах вэ? гэж бодож байгаад эхэлсэн миний хувьд шөвгийн шалгаруулалтад үлдэнэ гэдэг тэр чигтээ сэтгэл хөдлөм Бурханы ивээл юм. Библийн ишлэлийг цээжлэнгээ, сэтгэл хөдлөж, өдөр тутмын

итгэлийн амьдралд библийн үг сургаал шууд шууд бууж ирнэ гэдэг нь үнэхээр сайхан байна.” гэж сэтгэлээ хуваалцсан юм.

Энэ удаагийн сургаал үгсийн тэмцээний тэргүүн байрыг 31-р бүлгийн ахлагч Ким Хёон жү номлогч эзлэж, цом болон ариун аялалаар явах эрхийн бичгээр шагнуулсан бол алтан медалийг 4 Канаан багийн Ким Сан гюн сүмд үйлчлэгч, мөнгөн медалийг Дэежон Манмин цуглааны Ан Ге хёон сүмд үйлчлэгч, болон Паг Хүн ёон пастор, хүрэл медалийг Дэежон Манмин цуглааны Хо Нам сүг номлогч, 1 Канаан багийн И Сүн жү сүмд үйлчлэгч, Масан Манмин цуглааны Ким Сүн ёон халамжлагч тус бүрт шагналыг нь гардуулсан юм. Үүнээс гадна шөвгийн шалгаруулалтад үлдсэн бүх оролцогчдод гарын бэлэг, эцсийн шалгаруулалт үлдсэн бүх оролцогчдод хичээл зүтгэлийн тусгай шагналаар шагнасан юм.

Энэтхэг-Хятадын хойг дахь номлогчдын семинар



2018 оны 9-р сарын 4-5 нд хоёр өдрийн турш “Энэтхэг-Хятад хойг дахь номлогчдын семинар”-т Тайланд, Мьянмар, Лаос, Вьетнам, зэрэг улс орны хамарсан 100 орчим хүн оролцсон уг семинар Тайландын хилийн ойролцоох Мэе Сай хотын Кун Жэ юут номлогчын а Мэе Сай цуглаанд болж өнгөрлөө.

Уг семинарын номлогч И Жей вон пастор (Тайланд Ченнай Манмин цуглааны ахлагч) нь И Жей руг тэргүүн пасторын сургаал ‘Загалмайн утга учир’-н <Хүн төрөлхтөнийг дасгалжуулдаг Бурхан>, <Сайн мууг мэдүүлэгч жимсийг тавьсны учир шалтгаан>, <Есүс Христ бидний Аврагч болсон учир>, ‘Сүнс, сэтгэл бие’ гэсэн сургаалиудыг заасан юм. Оролцогчид загалмайн утга учир болон Бурханы хайрыг Ариун Сүнсний

бялхал дотор маш тодорхой тайлж өгсөн И Жей руг тэргүүн пасторд талархлаа илэрхийлж байлаа.

Энэ удаагийн семинараар дамжуулан оролцсон номлогч нар хүн төрөлхтөнийг бүтээж, дасгалжуулдаг Бурханы агуу зорилго ба далдлагсан нууцууд, Эзэний загалмайд агуулагдсан гүн сүнслэг утгыг ухаарч, маш ивээл авч, үүнээс гадна гэрчлэл, магтаал, Ариун Сүнсээр бялхах залбирал баримтат кино зэргээр Ариун Сүнс дотор нэгдсэн үнэн ба ивээлээр бялхсан гайхалтай цаг байлаа.



Амар тайван ба эвтэй байдлын мэргэн ухаан

“Харин дээрээс ирэгч мэргэн ухаан нь нэгд ариун, тэгээд амар тайван, эелдэг, ул суурьтай, өршөөл ба сайн үр жимсээр дүүрэн, ялгаварладаггүй, хоёр нүүр гаргадаггүй аж. Үр жимс нь зөв байгчийн үр нь амар тайвныг бүтээгчдээр амар тайванд таригддаг юм” (Иаков 3:17-18).



Манмин төв чуулганы тэргүүн пастор,
И Жей руг пастор

- Есүс Христийн нэгдсэн ариун урсгалын ерөнхий удирдагч
- Христийн сайн мэдээ сэргэлтийн холбооны ерөнхийлөгч
- Үндэсний хайрын залбирлын нэгдсэн хорооны хамтын удирдагч
- (GCN) (Жи Си Эн) Глобал Христийн телевизийн ерөнхий захирал
- (WCDN) Дэлхийн Христэд итгэгч эмч нарын холбооны ерөнхий захирал
- (MIS) Манмин олон улсын библийн их сургуулийн захирал
- Нэгдсэн ариун библийн сургуулийн захирал
- Библи судлалын доктор, Теологийн хүндэт доктор
- Христийн телевиз, радиогийн албан ёсны сургаал заагч
- Чусон илбу, Жүнан илбу, Туна илбу, Хангүг илбу, Сөүл сонин Хангёорэ сонин, Кёонхян сонин, Хангүг кёнжэ сонин, Ши са ньюс, Кристиан сонин зэрэг өдөр тутмын сонин, сэтгүүлд итгэлийн амьдралын тухай байнгын нийтлэгч
- АНУ-н Нью-Йорк, Вашингтон, Балтимор, Мерилэнд, Лос-Анжелос, Хавай, Япон, Пакистан, Филиппин, Аргентин, Гондурас, Перу, ОХУ, Герман, Кени, Танзани, Уганда, Конго бүгд найрамдах улс, Израйль Иерусалим, Эстони зэрэг улс орнуудад нэгдсэн их цуглааныг удирдан явуулсан

Хүн амьдралынхаа хугацаанд зайлшгүй хэн нэгэнтэй хамт амьдардаг. Гэртээ бага балчир байхдаа эцэг эхийнхээ хайр халамжийнд өсч бойжин, өсөж томроод сургууль дээр найзуудтайгаа олон цагыг өнгөрөөдөг. Хүн болгон өөр өөр нөхцөлд төрж, өсч бойжин, боловсрол эзэмшсэний дараа нийгмийн нэг хэсэг болж тэдэнтэй хөл нийлүүлэн ажиллах болдог. Энэ л үед бие биедээ өөрийн зөв хэмээн үзэл бодлоо хамгаалан зүтгэвэл эв нэгдэл хагарч, сэтгэл шархлах явдал элбэг тохиолддог.

Тиймд гэртээ юмуу сургууль дээрээ, ажлын талбар зэрэг өөрт хамаарах газар болгондоо бүх зүйлийг бүтэмжтэй сайхнаар гүйцэлдүүлэхийн тулд ‘Бүх хүмүүстэй байж чадах мэргэн ухаан’ хэрэгтэй юм. Дээрээс ирэх энэ эвтэй байдлын мэргэн ухаан нь бүх үйлсээ Бурхан хүсэл дотор шийдэх түлхүүр төдийгүй Бурханы хүч ба ивээлийг хүлээн авах ерөөлийн суваг болдог. Ийм мэргэн ухаантай бол хүмүүсийн сэтгэлийг хөдөлгөж, зүрх сэтгэлээ нэгтгэж, арвин их ургац авах боломжтой.

1. ‘Эв нэгдэл’-н сүнслэг утга

Хэлний тайлбар толь дээр үзвэл ‘Эв нэгдэл’ нь ‘Зүрх сэтгэл баяр хөөртэй амар тайван, бие биетэйгээ эвтэй бөгөөд амар амагалан’ гэж тодорхойлсон байдаг. Бурхан хайрт хүүхдүүдээ үргэлж эвтэй байхыг хүсдэг. Хоорондоо харьцаа муутай, өчүүхэн тавгүйтэл сэтгэл хөдлөлөөр зөрчилдөх, муудалцахгүй байхыг хүсдэг. Тэгвэл ‘Эв нэгдэл’-н сүнс талын утга нь ‘Бүгдийг хайрлаж чадах хангалттай уужуу сайхан сэтгэл’ гэж хэлж болох юм.

Хэн ч өөрийн сайн ханддаг хүнтэйгээ эвтэй байх амархан байдаг. Гэтэл хайрын Бурханы хүсэж буй эвтэй байдал нь ‘Бүх хүнтэй эвтэй байх’ явдал юм. Зарим хүнтэй сайн харилцаатай, заримтай нь тавгүйтэх байдлаар хандах бус, уужуу сэтгэлээр бүх хүмүүсийг сэтгэлдээ өвөрлөж, эвтэй байхыг хэлдэг. Гэхдээ зүрх сэтгэлд сайн хандлага байхгүй бол хичнээн хичээгээд ч бүх хүнтэй эв нэгдлийг тогтоох нь амаргүй хэрэг юм. Өөрийнх нь хүсээгүй нөхцөл байдалтай тулгарвал гадна талаар эвтэй юм шиг боловч сэтгэл дотроо энэ байдал ганхаж болох юм.

Тийм ч учраас Бурханы хүсэж буй эв нэгдлийг бий болгохын тулд юуны түрүүнд эхлээд ‘Өөрөө өөртэйгөө эвтэй байх’ хэрэгтэй юм. Сэтгэлдээ үзэн ядалт, атаархал, бардамнал, нэрээ бодон өөрийгөө хэт үнэлэх, тавгүйтэл, таагүй сэтгэл хөдлөл зэрэг хорон муугийн хэлбэрүүдийг ч илрүүлэн хаяж, засах хэрэгтэй юм. Ийм л хүн эхнэр болон нөхөртэйгөө үр хүүхэд, найз нөхөд, ажлын хамт олон, хөрш зэрэг ‘Бүх хүнтэй эвтэй байх’ байдлыг бий болгож цаашлаад ‘Бурхантай эвтэй байдал’-г ч бий болгох боломжтой. ‘Бурхантай эвтэй байдал’-г бий болгон гэдэг нь Бурхан ба бид 2 хооронд гэм нүглээс үүдсэн хана байхгүй байдлыг хэлдэг.

Үнэндээ бид нар эвтэй байдлыг бий болгоход хамгийн чухал зүйл нь Бурхантай эвтэй байх явдал юм. Гэтэл Бурхантай эвтэй байхын тулд нэн тэргүүнд ямар ч хорон муугийн бүх хэлбэрийг санан хаяж өөрийгөө зассанаар ‘Өөрөө өөртэйгөө эвтэй байх’ байдлыг бий болгох хэрэгтэй юм. Өөрөө өөртэйгөө эвтэй хүн бусадтай ч эвтэй байж чаддаг.

Библид үзвэл аврагч Эзэнээр ирсэн Есүс сайхан

сэтгэлтэй цайлган хүмүүжилтэй хүмүүс, дару дөлгөөхөн дуулгавартай дагадаг хүмүүстэй л эвтэй байх бус хүмүүжил боловсрол муутай хүмүүс, гэм нүгэлтэн, татвар хураагчидтай харьцахдаа хүртэл хайраар үйлчилж, бүх хүнтэй эвтэй нэгдлийг тогтоосон юм. Түүнчлэн гэм нүгэл дотор амьдарч буй бүх хүмүүсийн төлөө ямар гэмгүй зөвхөн хайраараа загалмайд цовдлогдон нас барсанаараа авралын замыг нээж өгч, Бурхан ба хүний хооронд эвлэрүүлэл болсон юм.

2. ‘Бүх хүнтэй эвтэй’ байх ‘Мэргэн ухаан’-ы талаар

1) Бүх үйлсээ Бурханы хүсэл дотор шийддэг учир.

Энэ дэлхийд төрөл бүрийн хүмүүс амьдардаг. Мэдлэг боловсрол, нийгмийн өндөр байр суурьтай хэрнээ даруу дөлгөөн байдлаараа бүх талбарт хүмүүстэй сайн сайхан харилцаатай хүн байдаг бол бардамнадаг бусдыг үл тоомсорлодог хүн ч байдаг. Маш ухаалаг, чадварлаг хүн байлаа ч бусдыг үл тоож, эв түнжин хагалдаг хүн их хэргийг бүтээх бус харин ч хохирол амсч болзошгүй юм.

Жусон улсын үед Жу Гуан жу гэж хүн хаан болон ард түмнийхээ төлөө гэсэн сэтгэлээр тууштай зоримог шинэчлэх бодлого явуулах гэж байлаа. Түүний хүсэл зорилго тодорхой байсан тул хаан ч эхэндээ түүнийг ихэд сайшаан түлхэц болж, ард олон ч түүнд их дэмжлэг болж байлаа. Гэтэл дэндүү хатуу байдлаар огцом байдлаар ажил хэргээ явуулж байхдаа эсэргүүцэлтэй тулгарсан ч эцсээ хүртэл өөрийн үзэл бодлоосоо ухраагүй тул түүнийг дэмжиж хаан хүртэл түүнээс нүүрээ буруулсан байдаг.

Эцэстээ тэрээр өөрийн хийх гэсэн шинэчлэх бодлогоо явуулж ч чадалгүй муу нэр авч цаазлуулсан юм. Тэрээр өчүүхэн төдий л эргэн тойрноо ажиглаж, эсрэг талынхнаа ойлгож өгсөн бол өөрийн хүсэл төлөвлөгөөгөө биелүүлж болох байсан юм. Мөн өөрийн үзэл бодлоо хэт хамгаалснаас болж, эв түнжин хагарснаар ийм байдалд хүргэсэн юм. Хэрэндээ сайн сайхан сэтгэлээр санаачилсан ч мэдлэг болон найдвартай арга барил байлаа ч энэ нь огт хэрэггүй болж хувирдаг.

Бид ч эргэн тойрондоо ийм зүйл харж болох ба зарим хүн ажилдаа ололт амжилт их олдог ч бусад нэр хүнд тааруу, үр дүн муу байх тохиолдол их байдаг. Дуг Бул жанжин шиг өөрийн хүч болон ухааныг л түрүүнд тавьснаар хүмүүсийн дургүйцлийг хүргэж сэтгэлийг шархлуулдаг учраас юм. Бусад хүмүүсийн санал, нөхцөл байдлыг үл тоож, өөрийнхөөрөө зөрүүдлэн өөрийн хэв шинж, стилээр шахах үед доор ажилладаг хүн юм уу бусад салбар хэлтэсийн хүмүүс, тэр ч байтугай харилцагч нартайгаа ч сөргөлдөж болзошгүй юм. Ийм дахин давтагдах тусам уур амьсгал эвддэг хүн гэсэн муу нэр сонсч, зожиг ганцаардмал болж, өчүүхэн алдаанаас үл тоогдох байдалд хүрдэг. Тиймээс хичнээн чадварлаг байсан ч эв нэгдэл хагалан байж ажил явуулж байвал эцэстээ мэргэн ухаан дутсан үйлдэл юм.

2) Бурхан хүч чадварыг нэмж өгөн үр жимсийг нь нотолж өгдөг учир.

Бид эв нэгдлийг бий болгоно гэдэг нь Бурханы ажлыг хийхэд маш чухал зүйл юм. Хичнээн ухаалаг, чадварлаг байсан ч эв нэгдэл хагалдаг хүн Бурханд хэрэглэдэхэд хэцүү юм. Ажлыг төлөвлөж, хийж зүтгэдэг нь хүн

Монгол Манмин Сүм

Мөргөлийн цаг

| Мөргөл | Цаг |
|-------------------------------|--------------------|
| Их мөргөл | Ням гариг 10:30 |
| Үдээс хойш мөргөл | Ням гариг 13:30 |
| Хүүхдийн цуглаан | Ням гариг 10:00 |
| 3 дахь өдрийн мөргөл | Лхагва гариг 18:00 |
| 5 дахь өдрийн мөргөл | Баасан гариг 22:00 |
| Эмэгтэйчүүдийн багийн цуглаан | Лхагва гариг 16:00 |
| Шинэ итгэгч нарын сургалт | Бямба гариг 14:00 |

Залбирлын цаг Цаг

| Ангилал | Цаг |
|------------------------|-------------------------|
| Даниел үүрийн залбирал | Даваа-баасан 5:00-6:00 |
| Даниел өдрийн залбирал | Даваа-баасан 9:00-10:00 |
| Даниел оройн залбирал | Өдөр бүр 18:30-20:00 |



Хаяг: Баянгол дүүрэг 16-р хороо Орхоны 1-33А Чуулганы ахлагч П.Батзориг
Утас: 88107327, 91170773, 89737773

www.manmin.org
www.gcntv.org

боловч үр жимсийг боловсруулагч нь амьд оршигч Бурхан юм.

Хэрэв эв нэгдэл хагарвал сатан диаволын уруу татлага орж ирэх тул Бурхан нөлөөлөх боломжгүй байдаг. Хичнээн хүний үүднээс шаргуу ажиллаж байгаа мэт бол сүнс талаар хангалуун үр жимс гардаггүй ажлыг удирдаж байгаа хүмүүсийн хувьд хааяа эв нэгдэлийн тухай байдал асуудал болдог.

Эзэн дотор зарим хүн чадварлаг, Бурханы хаанчлалын төлөө зүтгэх халуун сэтгэлтэй байвал сайн ч түүнд үүрэг хариуцуулж өгөхөд эргэлзэх үе бас бий. Тэрээр үүрэг авбал “Энэ илүү сайн, ингэж хийх ёстой” гэж өөрийн үзэл бодлоор зөрүүдлэн бусад хүмүүсийг хэцүү байдалд оруулж, шархлуулах зэрэг янз бүрийн хэл ам сонсогддог учраас юм. Энэ нь газар авбал эргэн тойронд “ийм хүнтэй, тэр хүнтэй ажил хийхэд хэцүү байна” гэлцэн хамт байхаас халшрах хөндийрөх байдал гардаг.

Мэдээж итгэлтэй хүмүүс түүний төлөө өөрийн тавгүй байдлаа хянадаг байна. Харин ч Бурханы ажил үүрэг аваад эрч хүчтэй итгэлийн амьдралаар амьдрахад нь дэм болж үйлчилж, халамжилж өгдөг. Энэ мэт таагүй сэтгэл хөдлөлөө хянаж, бусдыг халамжилдаг хүн тэнгэрийн орны шагнал том байх ч аар саар юм болгонд сөргөлддөг хүнд огт шагнал байдаггүй анхаарах хэрэгтэй юм. Мөн Бурхан ажлыг хийхдээ эвтэй байна гэдэг нь маш том мэргэн ухаан юм. Хүч чадвар дутсан ч эвтэй байснаараа Бурхан хүч чадлыг нэмж өгсөнөөр түүний үр жимсийг баталж өгдөг.

3. Бүх хүнтэй эвтэй байхын тулд бусдын эрх ашгийг хайх хэрэгтэй

Бурханы хүссэний дагуу ‘Бүх хүнтэй эвтэй байх’-г бий болгохын тулд юуны өмнө зүрх сэтгэлдээ сайныг бий болгох хэрэгтэй. Эв нэгдэл хагалдаг

хүмүүс ч өөрийгөө ийм атгаг байгаагаа бодож үзээгүй үе байдаг. Гаднаасаа сайн сайхныг ярьдаг ч үнэндээ өөрийн эрх ашгийг хайх сэтгэл байх тул эв түнжин хагардаг. Үнэхээр сайныг дагадаг хүн бол эв нэгдэл хагалдаггүй. Бурхан бие биенийхээ эрх ашгийг хайж үйлчлэхийг хүсдэг.

Гэр бүлийн хоёрын хооронд ч өөрсдийн эрх ашгийг хайдаг учраас асуудал үүсдэг. Эсрэг талын хүн шууд өөрт нь нийцүүлж өгөхийг шаардаж, өөрөө бусдад хийж өгсөн хэмжээгээр авах гэдэг. Тэгэх тусам өөрийн хүслийн дагуу болохгүй бол тавгүйтэж, энэ цаашид давтагдсаар байвал хосуудын хоорондын харилцаанд ан цав гардаг. Гэр бүлийн хос төдийгүй найз нөхөд, ажлын хамт олон, хөрш хоорондын харилцаанд ч өөрсдийн эрх ашгийг хайлгүй, бие биенээ хүндэтгэн үйлчилдэг эв нэгдэл хагарах асуудал гарахгүй юм.

Гэвч энэ ч зүйл, тэр ч зүйл боломжтой нөхцөлд өөрийн хүсэж байгаа тал руу зөрүүдэлвэл эвтэй байдал алдагдах болдог. Миний хувьд илүү сайн зөв зүйл, надад үр ашигтай зүйл, надад таатай, тухтай зүйл, намайг илэрхийлэх өргөх зүйл рүү зүтгэдэг учраас юм. Хэдийгээр үнэний сургаал сурч мэдсэн ч сэтгэлдээ сайныг бий болгож чадаагүй үед эцэстээ үг болон үйлдлээрээ ч сайн үйлс гардаггүй. Өөрт нь жоохон илүү ашигтай тал руу зөрүүдлэх учир бусдыг хатгах, шархлуулах, бүдүүлэг үйлдлүүд гарч ч болзошгүй юм.

Харин эсрэгээрээ зүрх сэтгэлдээ цайлган сайн хүн бүх тал дээр бусдын сэтгэлийг тайван болгож үйлддэг. Бурханы хаанчлалд илүү ашигтай зүйлийн төлөө гуйхын хамт бусдад ч мөн явал үр дүнтэй байж болох талаар давхар бодолцдог. Бусад хүн ёс бус зүйлийг хийх л биш дээд зэргээр түүнд нийцүүлж өгөх хэрэгтэй юм. Хэдий миний зөв ч бусад хүн өөр саналыг тавихад өөрийн санал дээр

зөрүүдэлдэггүй.

Бурхан хайрладаг хүүхдүүд хоорондоо тавгүйтэх юм уу, муудалцах зүйл байхгүй эвтэй байхыг хүсдэг. Ямар ч ажилд, ямарч хүнтэй бие биенээ хайрлаж, тайтгаруулж, үйлчилж өгснөөрөө эвтэй байхыг чин сэтгэлээсээ хүсдэг. Бид эвтэй байдлыг бий болгохын тулд юуны түрүүнд Бурхан руу хандах бидний сэтгэл юм. Чин сэтгэлээсээ бусдад үйлчилж, зориулж, даруу болгох тусам ямар ч хүнийг өвөрлөж чадах ба хорон муу хүнийг ч хүртэл өөрчилж чадах юм. Зөвхөн мөргөлдөхөөс айж, эсвэл хүмүүст хүлээн зөвшөөрөгдөхийн тулд зохицох бус үнэнээс холдсон замаар явбал энэ Бурханы өмнө эвтэй байдал биш юм.

Тиймээс бид нар эвтэй байхын тулд анхаарах ёстой зүйл нь эв байдлыг бий болгож байна гэдэг шалтгаанаар худал хуурмагтай зохицож болохгүй юм. Хэрэв ‘Хавчиж байгаа гэр бүлийнхээ хүссэнд нийцүүлэхийн төлөө өнөөдөр мөргөлд очихгүй байя’ гэж бодвол энэ нь эвтэй байдал биш юм. Ийм тохиолдол даамжирах тусам өөрийгөө төдийгүй бусдыг ч Бурханаас холдуулж мөхлийн замаар явах болно.

Хайрт итгэгч та бүхэн, Сургаалт үгс номын 16:7д “Хүмүүний зам ЭЗЭНий таалад нийцэх цагт Тэрээр түүний дайснуудыг нь хүртэл түүнтэй эв түнжинтэй байлгадаг” гэж айлдсаны дагуу хүний жинхэнэ эвтэй байх гэдэг нь эхлээд Бурханыг баярлуулах хэрэгтэй юм. “Бүх хүнтэй эвтэй байхыг болон ариусгалыг мөшгөгтүн” (Еврей 12:14) гэсэн бол “Тэгээд бузар муугаас эргэж, сайныг үйлд. Амар тайвныг хай, түүнийг мөшгө” (1 Петр 3:11) д айлдсанчлан ариун байдлыг олж эвтэй, амар амгалан ухаантайгаар Бурханы арвин дүүрэн хүч нөлөөг авахыг Эзэний нэрээр хүсэн ерөөе.

Thailand



Хүсэн тэмүүлсээр Манмин бүх итгэгчдийн зуны цуглаанд оролцсон Тайланд залуучууд


Энэ жил Манмин бүх итгэгчдийн зуны цуглаанд Тайланд Ченнай Манмин чуулган (И Жей вон пастор)-аас 27 хүн ирсэн бөгөөд түүний 20 нь өсвөр насны болон залуучууд байлаа. Тэд нар сүнсээр өсөх, тэмдэг гайхамшиг, эрх мэдэлт хүчийг мэдэрч, анх Эзэнтэй уулзсан халуун байдал ба хайраа сэргээх, ертөнцийг хайрлах сэтгэлийг хаях зэрэг төрөл бүрийн зүрх сэтгэлийн хүсэл тэмүүлэлээ өвөрлөн залбирал болон мацаг барилтаар зуны цуглаанд оролцох гэж бэлдсээр иржээ.

Ялангуяа тэдний зарим нь ахлах сургуулийн сурагч, оюутан залуучууд тул санхүү мөнгөний хангалуун бус байдалд байсан ч тэд зуны цуглаанд оролцохын тулд хэрэглээний мөнгө гамнаж, цагийн ажил хийж, сар бүр мөнгөө цуглуулан, Залуу эмэгтэйчүүдийн удирдагчийн дэмжлэг болон зохион байгуулалтайгаар тэд халуун сэтгэлээр бэлдсэнээр эцэстээ өөрсдийн хүслээ биелүүлсэн юм.

Хүсэл тэмүүлэл том байх тусам тэд “Манмин төв сүмийн төв танхимд мөргөлд оролцохыг хүсэж байсан ба тэдний мөрөөдөл биелэгдээд маш их баяртай байна”, “Зуны цуглаанд оролцоод сүнс махан талаа маш их өөрчлөгдсөн”, “Зуны цуглаан болж байгаа газар сэрүүн таатай цаг агаараар хамт буй Бурханы хайрыг мэдрэн, олон хүмүүс эдгэрч, байгааг хараад илүү итгэлтэй болсон”, “Соно миний гар нь дээр суухад Бурхан Аавын халуун хайрыг мэдэрч үзлээ.” хэзээ ч мартаггүй Манмин зуны цуглаанаас авсан ивээлээ баяртайгаар гэрчилж байлаа.



“
Соно нисэж
ирээд аяархан буухад
Бурханы хайрыг
ухаарсан юм.”



“Библид бичигдсэн гайхамшиг үйлс эрх мэдэлт хүчтэй гар алчуураар одоо ч илрэн гарсаар байна”

Варафун Иньватанакун пастор (59 нас, Тайланд, Чай Пракан Манмин сүм)

2008 онд нэгэн найзаасаа авсан “Эрх мэдэлт хүч” DVD-г үзээд би библи дээрх агуу гайхамшиг өгөө үед ч гарч байгааг хараад үнэндээ маш их сэтгэл хөдлөн Солонгос Манмин төв сүмд очин И Жей руг тэргүүн пастортой нүүрээрээ уулзаж үзсэн юм. Маш дөлгөөхөн халуун бөгөөд сүнс талын эрх мэдэл агуу болохыг мэдэрсэн юм.



Ариун Сүнсний бялхалыг авч би гар алчуур дээр И Жей руг тэргүүн пасторын залбирлыг авсан юм. Элч Паулын гар алчуураар дамжуулан өвчин эдгэрч, муу ёрын сүнс зайлах ‘Гайхамшигт

тэмдэг’ (Үйлс 19:11-12) илрэн гардаг шиг Манмин төв сүмд ч үүнтэй адил хүч нөлөө гарч байгаа учраас юм.

Түүний дараа би GCN телевизээр И Жей руг тэргүүн пасторын сүнслэг сургаалыг үргэлжлүүлэн хүлээн авсаар 2009 оны 5-р сард Манмины салбар сүм болон нэгдсэн юм.

Эрх мэдэлт гар алчуурын залбирлаар гарах Бурханы хүч нөлөө нь миний бодсоноос ч агуу байлаа. Тэргүүн пастораас залбирал авсан гар алчуураар хүрч, итгэлээрээ залбирал хийхэд алхаж чадахгүй хүн алхдаг болж, авто ослын улмаас ухаангүй болж биеийн тал саажсан хүү эргэн ухаан орж, бөө удган гэрийнхэн болон тэр тосгоны хүмүүс Эзэнийг хүлээн авч, ‘Назарет’ гэдэг нэрээр хүртэл тосгоныхоо нэрийг хүртэл сольсон юм. Үүнээс гадна манай цуглааны итгэгч нар өвдөх үед би эрх мэдэлт хүчтэй гар алчуураар залбирал хийж өгвөл тэр дороо эдгэрч баяр хөөртэйгөөр гэрчилцгээдэг.

Мөн 2017 онд Энэтхэг-Хятадын хойгд болсон номлогчдын семинарын номлогч И Хи сон пастор

(Манмин бүх салбар сүмийн ерөнхий удирдагч)-аас гар алчуурын залбирал авах тэр агшин, гал бууж ирэн зүрхний өвчнөөсөө эдгэрч, илүү эрч хүчтэй болсон юм.

Энэ жилийн 1-р сард эрх мэдэлт хүчтэй гар алчуураар залбирлаар дамжуулан нэгэн эмэгтэй хөхний хорт хавдрын эцсийн шатанд орсон маш их зовиуртай байдлаасаа төгс эдгэрч, Бурхандаа агуу алдрыг өргөсөн юм. Тэр эмэгтэйн нэг нутгийн хүнтэй утсаар ярьж байгаад хүнд өвчний улмаас босож ч чадахгүй хэвтэрт удаан байгааг сонсоод их харамсаж, гар утсан дээр эрх мэдэлт хүчтэй гар алчуураа тавиад залбирал хийж өгсөн юм. Түүний дараа утсаар залбирал авсан хүний бие сайжирч, босч, алхдаг болсон юм. Халлелүяа!

Энэ мэт миний үйлчлэлд эрх хүчийг буулгаж өгсөн ‘Манмин’-ы 8-р сарын эхээр би эхнэртэйгээ хамт Солонгост Манмины зуны цуглаанд 4дэх удаагаа оролцсон юм.

Зуны цуглааны эхний өдрийн сургаалийн цагаар илүү ихээр сүнс талын бялхалыг мэдэрч, үнэхээр сэтгэл хөдлөм байсан бол дараагийн өдөр галын наадам магтаалын цагт судасны нарийслаас үүдэлтэй цээжний хөндүүр арилсан ерөөл авсан юм.

Миний эхнэр (Дауам Сэнди ан) хувийн эмнэлэг эрхлэн явуулдаг ба GCN телевиз эмнэлэгтээ үзүүлж үзүүлэхээр ирсэн үйлчлүүлэгч нар аяандаа үзэж, сайн мэдээг сонсч байна. Тэргүүн пасторын залбирал гарах үед зурагтны өмнө очоод залбирах авах юмуу мөн залбирч өгөхийн гуйх үед эхнэр маань гар алчуураар тэдэнд залбирч өгдөг. Эдгэрэл ч сайн болж үйлчлүүлэгчид бүр дугаарладаг болсон.

Манмины үйлчлэл миний амьдралд хайр ба хүч чадлыг дүүргэж өгсөн Ариун Гурвал Бурхандаа бүхий л талархалыг өргөө.

‘2018 Манмины зуны цуглаан’д спорт тэмцээний буухиа гүйлтийн тамирчнаар орвол ямар вэ гэсэн санал ирсэн юм. Бурхандаа алдрыг өргөх явдал учраас зөвшөөрсөн ч орой илүү цагаар ажиллаад шөнө хүртэл бэлтгэл хийх тул бие маань нэлээн сульдаж байлаа. ‘Болдог ч юм билүү?’ гэж бодож байгаад хоньчиныхоо хүч болъё гэсэн бодлоор мэрийж хичээсээр байлаа.

Гэтэл зуны цуглаан болохоос 2 өдрийн өмнө буюу 8-р сарын 4 нд хөл бөмбөг тоглож байгаад зүүг хөлний гуяны урд талаар гэнэт хатган өвдөж маш зовиуртай болов. Хөлөө өргөж алхахад хүртэл хэцүү боллоо.

8-р сарын бны Зуны цуглаан эхний өдөр, Сургаалийн цагаар ‘Сүнслэг орон зай’ (Иохан 4:24) гэсэн сэдвээр И Сү жин пасторын сургаалийг сонсож байхдаа итгэлээрээ эдгэрч чадна гэсэн амар тайван бууж ирсэн юм. Сургаалийн дараа





“Эзэний хайраар гүйх болсондоо үнэхээр жаргалтай байна”

Им Жон хүн ах дүү
(26 нас, 3-р Залуучуудын баг)

И Жей руг тэргүүн пасторын залбирч өгсөн эрх мэдэлт хүчтэй гар алчуур (Үйлс 19:11-12) аар индэр дээрээс өвчний эдгээх залбирал хийж өгөхөд зүүн гуяны шөрмөснүүд өөрөө хөдөлж байгааг мэдэрсэн юм. ‘Эдгэрсэн!’ гэж итгэлтэй байлаа.

Тэгээд залбирал авсаны дараа хөлөө хөдөлгөөд үзтэл ямар ч зовиургүй цэвэрхэн эдгэрсэн болохоо шалгаж мэдсэн юм. Маргааш өдөр мэдээж спорт тэмцээнд буухиа гүйлтийн төрөлд оролцож манай баг алтан медал авсан тул илүү их баяртай байв. Халлелүяа!

Үнэндээ төрсөнөөс хойш 4 сартайдаа уушгины сүрьеэ өвчнөөр өвдөж, бүрэн эдгэрч чадалгүй үргэлж эмнэлэгээр явдаг байсан юм. Гэтэл 2006 онд Манмины итгэгч болж анх удаа Манмины зуны цуглаанд оролцоод өвчнөөсөө эдгэрч одоо хүртэл эрүүл энх байна. Тухайн үед зуны

цуглааны эхний өдрийн сургаалийн цагын өмнөөс эхлээд толгой эргээд, халуурч, босож ч юм идэж ч чадахгүй тэр ч байтугай амьсгалахад хүртэл хэцүү байсан юм. Гэсэн тэргүүн пасторын индэр дээрээс бүх хүмүүс хандан өвчин эдгээх залбирлыг аваад 13 жилийн турш зовоож байсан уушгины сүрьеэ өвчнөөсөө бүрэн эдгэрсэн юм.

Тийм ч учраас ингэж эрүүл, эрч хүчтэй гүйх боломжтой болсон нь хичнээн талархалтай хэрэг вэ. Эдгээж өгч, итгэл өгсөн Бурхан Аавдаа бүх л талархал ба алдрыг өргөн үнэт цусаараа миний гэмийг угааж, аварч өгсөн хайрын Эзэндээ талархалыг өргөө. Мөн Бурхан Аав болон Эзэний тухай мэдүүлж өгч, хамгийн үзэсгэлэнтэй Тэнгэрийн орон Шинэ Иерусалимын үнэт амьдрал руу удирдаж байгаа тэргүүн пастордаа талархал өргөө.

УБ Ариун баярт мэдээ чуулган

Мөргөлийн цагийн хуваарь

| Мөргөл | Цаг |
|------------------------|---------------------|
| Хүндэтгэлийн их мөргөл | Ням гариг 10: 30 |
| Үдээс хойшхи мөргөл | Ням гариг 11: 30 |
| 3 дахь өдрийн мөргөл | Лхагва гариг 18: 00 |
| 5 дахь өдрийн мөргөл | Баасан гариг 21: 30 |
| Хүүхдийн цуглаан | Ням гариг 09: 00 |
| Сурагчдын цуглаан | Бямба гариг 15: 00 |
| Залуучуудын цуглаан | Мягмар гариг 17: 00 |

залбирал цагийн хуваарь

| Ангилал | Цаг | Удирдагч |
|-----------------------|--------------------------|----------------------------------|
| Үүрийн залбирал | 05:00-06:00 | Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч |
| Өглөөний залбирал | Даваа-Баасан 09:30-10:30 | Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч |
| Оройн Даниел залбирал | Өдөр бүр 18:00- 19:30 | Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч |

Манай хаяг:

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 10-р хороо 39-р сургуулийн чанх ард талд 2-р давхар саарал байр

Чуулганы утас: 7000-3707

Чуулганы ахлагчийн утас: 8870-3712

Е- шуудан : power3712@gmail.com

Mongolian

Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

Сөүл хот, Гүрү дүүрэг, дижитал-26-29тоот 152-848 Солонгос Улс
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048
http://www.manmin.org/english
www.manminnews.com
e-mail: manminnews@manmin.kr
Нийтлүүлэгч: Жаерок Лее
Редактор: Геумсун Вин